



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 47

Сүхбаатар сум

Комисс томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 66 дугаар зүйлийн 66 1.11, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5.3, 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.2022 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр зохион байгуулагдах төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

Э.Оюунболд

Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга

Нарийн бичгийн дарга

Ш.Энхмаа

Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

Ч.Даваадорж

Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн, Ахмад төрийн албан хаагчийн төлөөлөл

Техникийн ажлын хэсэг:

Д.Хишигбат


Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ч.Гандүүрэн

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Мэдээллийн технологи хариуцсан ахлах мэргэжилтэн

2.Шалгалтыг зохих журмын дагуу зохион байгуулж, дүнг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, шийдвэрийг холбогдох газарт хүргүүлж, хяналт тавьж ажиллахыг комиссын дарга (Э.Оюунболд), Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ш.Энхмаа) нарт даалгасугай.

ДАРГА



Ө.СУВДАА